

***Ц.Нацагдорж “Өргөөний баяр наадам” сонсоод 1-5 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

1. *Сонссон зохиолын эхний хэсгийн сүрлэг дуугаралттай уриа дуудлагын хэсгийг ямар хөгжмийн бүрэлдэхүүн зонхилох үүрэг гүйцэтгэж байна вэ? Тохирохыг сонгоорой.

A.



B.



C.



D.



2. *Сонссон зохиолын 2 дугаар хэсгийн аялгууны хурдад тохирохыг сонгоорой.

A. Маш удаан

B. Тэмүүлэлтэй

C. Хурдан

D. Дунд зэрэг

3. *Сонссон зохиолын хэсэг тус бүрийн утга санааг илэрхийлэхэд тохирох зурагтай зөв харгалзуулсан хувилбарыг сонгоорой.

1-р хэсэг

2-р хэсэг

3-р хэсэг

a.



b.



c.



A. 1b 2c 3a

B. 1a 2b 3c

C. 1b 2a 3c

D. 1a 2c 3b

4. *Сонссон зохиолын хэсэг тус бүрд тохирох ноот бичлэгийг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу.

1-р хэсэг

a.



2-р хэсэг

b.



3-р хэсэг

c.



A. 1b 2c 3a

B. 1a 2b 3c

C. 1b 2a 3c

D. 1a 2c 3b

5. *Сонссон бүтээлийг хөгжмийн урлагийн ямар төрлөөр бичсэн байна вэ? Сонгоорой.
- A. Дуурь- Урлагийн олон төрлүүдийн нийлбэрээс бүрдсэн зохиол.
B. Бүжгэн жүжиг- Бүжиг, хөгжмийн нийлэмжээр дүрслэл, утга агуулгаа илэрхийлдэг.
C. Сонат: Зөрчилт хөгжим- гоцлол, цөөхүүл хөгжмийн нэг төрөл.
D. Симфони- Дан хөгжмийн зохиолын хамгийн том төрөл.

6. Зургийг ажиглаад сонгодог урлагийн төрөлд хамаарахыг сонгоорой.

A.



B.



C.



D.



7. Симфони найрал хөгжмийн бүрэлдэхүүнд хамаарахгүй хөгжмийн зэмсэг аль нь вэ?

A.



B.



C.



D.



8. Дуулаачийн төрлүүдийг үүрэгтэй нь холбоод зөв хувилбарыг сонгоорой.

1.

Ари

A.

Дуулах өнгө аялга, темп, үг хэллэгээ нийцүүлэн, олон хоолойгоор дуулах онцлогтой дуурьт ард түмний санаа бодлыг төлөөлдөг

2.

Речитатив

B.

Дуурийн гол дүрийн зан төрх, дотоод сэтгэхүй, үзэл санааг илэрхийлсэн, симфони найрал хөгжимтэй хамтран дуулахад зориулсан гоцлол төрөл

3.

Хоршил

C.

Ахуйн яриан хэллэг аялга хэмнэлд оруулсан дуулаачийн нэг төрөл. Яруу найргийн агуулга, хэмнэлд зохицуулан ярих мэт дуулах төрөл

4.

Найрал

D.

Хоёр хүний бүрэлдэхүүнд зориулсан чуулга бүтээл, хэдэн хүнд зориулсан гэдгээс шалтгаалан дуэт, трио, квартет гэх мэт ангилдаг төрөл

A. 1c 2a 3d 4b

B. 1b 2a 3d 4c

C. 1a 2b 3d 4c

D. 1b 2c 3d 4a

9. Дуулаачийн төрлүүд аль бүлэгт хамаарах вэ? зөв хувилбарыг сонгоорой.

- | | | |
|----|--|---------------------------|
| 1. | | a. Нэг төрлийн холимог |
| 2. | | b. Хоршил, гурвал, дөрвөл |
| 3. | | c. Ари, речитатив |

A. 1c.2a 3b

B. 1c 2b 3a

C. 1a 2c 3b

D. 1a 2b 3c

10. Соль түлхүүрийн ард байгаа бемолийг зөв нэрлэсэн хувилбарыг сонгоорой.



A. Си бемоль, Ми бемоль

B. Соль бемоль, До бемоль

C. Соль Диез До диез

D. Си диез, Ми диез

11. Зургаас гуулин үлээвэр хөгжмийн бүрэлдэхүүнийг сонгоорой.

A.



B.



C.



D.



12. Ноот бичлэгт тусгайлан тэмдэглэсэн тэмдгийн үүргийг сонгоорой.



A. Чанга

B. Зөөлөвтөр

C. Зөөлөн

D. Чангавтар

13. Бүжгийн төрлүүдийн тодорхойлолтыг зурагтай нь холбож үзээд, зөв хувилбарыг сонгоорой.

1.



A.

.....бүжиг буюу түгээмэл гэдэг нь тодорхой бүс нутаг, соёл, түүний уламжлалт уугуул зан заншилд үндэслэсэн бий болсон бүжгийн төрөл бөгөөд эрт дээр үеэс ёслол, зан үйлтэй холбоотой юм.

2.



B.

.....бүжиг нь сонгодог бүжгийн тогтоосон бүх схем, түүний хувилбаруудыг зөрчдөг бие махбодь нь тодорхой байр суурийг дагаж мөрдөх албагүй, харин сэтгэлийн байдал, илэрхийлэх санааны дагуу хөгждөг.

3.



C.

.....бүжиг нь гоо зүйн өндөр түвшний хэмнэлтэй, хөдөлгөөнүүдийн нэгдэл гэдгээрээ онцлог юм. Энэ төрлийн бүжиг нь дэглэлтээрээ дамжуулан сэтгэл хөдлөлийг илэрхийлэл, биеийн хамгийн нарийн хөдөлгөөнийг ил гаргахыг зорьдог

A. 1a 2c 3b

B. 1c 2b 3a

C. 1c 2a 3b

D. 1a 2b 3c

14. Монголын хамгийн анхны симфони хэний ямар зохиол болохыг сонгоно уу.

A. Л.Мерддорж “Миний эх орон”

B. Ц.Нацагдорж “Өргөөний баяр наадам”

C. Э.Чойдог “Монголын сайхан орон”

D. Б.Шарав “Сэрсэн тал”

15. Сонгодог бүжгэн жүжгийн төрлүүдийг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоорой.

1. Хоршил

a. Па-де-труа

2. Гурвал

b. Па-де-катр

3. Дөрвөл

c. Па-де-де

A. 1c. 2a 3b

B. 1c 2b 3a

C. 1a 2c 3b

D. 1a 2b 3c

16. “Цөмөөхэй” бүжгэн жүжиг хэний бүтээл вэ?

A. П.И.Чайковский

B. С.Прокофьев

C. В.А.Моцарт

D. Л.В.Бетховен

17. У.Шекспирийн эмгэнэлт жүжгийн үндсэн зөрчлийг хөгжмийн хэлээр харуулсан Оросын хөгжмийн зохиолчыг сонгоорой.

A. П.И.Чайковский

B. С.Прокофьев

C. В.А.Моцарт

D. Л.В.Бетховен

18. Монголын сонгодог бүжгэн жүжгийн анхдагч хэдэн онд тавигдсан бэ?

A. 1940

B. 1953

C. 1956

D. 1958